



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2, 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК-иас ирүүлсэн хүсэлтийг хянан хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Цахилгаан, дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх диспетчерийн зохицуулалтын үйлчилгээний төлбөр буюу тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан диспетчерийн зохицуулалтын үйлчилгээний төлбөр буюу тарифын дагуу "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК (Г.Балжинням)-тай аж ахуйн гэрээ байгуулан мөрдөж ажиллахыг "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХХК (Р.Дагдан), "Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХХК (В.Адъяа), "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХХК (Н.Мөнгөнхөлөгт), "Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХХК (Ц.Хангай), "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХХК (Г.Баярсайхан), "Дарханы дулааны сүлжээ" ТӨХХК (Д.Гантуул), "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХХК (Г.Отгонбаатар), "Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХХК (Т.Жаргалсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 55 дугаар тогтоол, "Тарифт өөрчлөлт оруулах тухай" 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 510 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.


4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Г.Эрхэмбаяр)-нд даалгасугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ




А.ТЛЕЙХАН

Э.ТҮВШИНЧУЛУУН

Б.БАТТУЛГА

Э.САМДАН

Эрчим хүчний зохицуулах хорооны
2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн
24 дүгээр тогтоолын хавсралт



**ЦАХИЛГААН, ДУЛААН ТҮГЭЭХ, ХАНГАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧДЭЭС ТӨЛӨХ ДИСПЕТЧЕРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР БУЮУ ТАРИФ**

1. Диспетчерийн зохицуулалтын үйлчилгээний төлбөр буюу тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид	Үйлчилгээний төлбөр буюу тариф /мянган төгрөг/
1	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	4,459,071.7
2	"Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	2,336,098.7
3	"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	759,146.2
4	"Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ" ХК	780,221.8
5	"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК	1,132,454.7
6	"Дарханы дулааны сүлжээ" ТӨХК	97,103.1
7	"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК	445,416.3
8	"Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	189,385.1
Нийт дүн		10,198,897.6